# ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

**Ж-2-ЕР-07-01**

# ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ЖУРНАЛ КЛУБЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

ЭХ ХУВЬ 1

<table>
<tr><td colspan="5">Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба</td></tr>
<tr><td colspan="2">Баримт бичгийн дугаар:<br>**Ж-ЕР-2-07-01**</td><td colspan="3">Эрдэм шинжилгээний журнал клубын үйл ажиллагааны журам</td></tr>
<tr><td>Хувилбар №01</td><td>Хэрэгжиж эхэлсэн огноо: 2021.05.14</td><td>Өөрчлөлт 0</td><td>Өөрчлөлт хийн шинэчилсэн огноо: 2021.05.05</td><td>Хуудас 1/</td></tr>
</table>

| Боловсруулсан: | Хянан засварласан: | Хянасан: | Баталсан: |
|---|---|---|---|
| Сургалт төслийн ажилтан | Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн албаны дарга | Цусны чанар аюулгүй байдлын албаны дарга | Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн ерөнхий захирал |
| М.Мэндбаяр | Н.Янжиндулам | Т.Алимаа | Н.Эрдэнэбаяр |
| Огноо: 2021.05.05. | Огноо: 2021.05.10 | Огноо: 2021.05.13. | Огноо: 2021.05.20 |
| Гарын үсэг | Гарын үсэг | Гарын үсэг | Гарын үсэг |

| | | |
|---|---|---|
| ... хийгдээгүй | Албан тушаал | Гарын үсэг |
| | ЭШМТА | |
| | ЦЧАБА дарга | |
| Хүчинтэй хугацаа | 20 23 он 05 сар 12 өдөр | |

## Агуулга


| Д/д | Бүлэг | хуудас |
|---|---|---|
| 1. | Өөрчлөлт оруулсан бүртгэл | 4 |
| 2. | Тодорхойлолт, товчилсон үг | 5 |
| 3. | Зорилго | 5 |
| 4. | Хамрах хүрээ | 5 |
| 5. | Хариуцлага, Эрх үүрэг | 5-6 |
| 6. | Журмаар зохицуулах үйл ажиллагаа | 6-8 |
| 7. | Лавлах, эш татсан материал | 8 |
| 8. | Хавсралт | 8-9 |
| 9. | Холбогдох баримт бичиг | 10 |

1. **Өөрчлөлт оруулсан бүртгэл**

| Д.д | Хуудас № | Бүлэг № | Өөрчлөлт оруулсан огноо | Оруулсан өөрчлөл-тийн утга | Шалтгаан | ЧАД-н гарын үсэг | Ерөнхий захирлын гарын үсэг |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |

2. **Тодорхойлолт, товчилсон үг Тодорхойлолт:**

Журнал клуб – Журнал клуб нь 2 ба түүнээс дээш хүмүүсийг хамруулсан үйл ажиллагааны хүрээнд тасралтгүй хөгжих, сурч боловсрох, шинэ арга барилаас суралцах, шинжлэх ухаанч мэдлэг чадварыг эзэмшүүлэх сургалтын хэлбэр юм.

**2.1.** Товчилсон үгийн тайлал:

Монгол нэршил:

- ЦССҮТ- Цус сэлбэлт судлалын Үндэсний төв
- ЭШ – Эрдэм шинжилгээ, судалгаа
- ЭШМТА- Эрдэм шинжилгээ, мэдээлэл технологийн алба
- ЖК – Журнал клуб

Англи нэршил:

- PDF – (Portable document format)
- PPT- (PowerPoint) – Илтгэл тавих формат
- JPG- (Joint photographic group)
- Excel – Офисс программ
- Critical Appraisal analysis- Шүүмж, үнэлгээний анализ
- JIF- Journal impact factor
- Peer - reviewed journal – Шинжлэх ухааны судалгаа талаасаа хянагдсан, мэргэжилтнүүдийн өгүүлэл, хэвлэлүүд
- Google Classroom- Журнал клубын тусгай цахим анги

3. **Зорилго:**

Эмнэлгийн мэргэжилтнийг тасралтгүй хөгжүүлэх ажлын хүрээнд сүүлийн үеийн нотолгоонд сууриласан шинжлэх ухааны судалгаа, бүтээлд дүн шинжилгээ, шүүмж хийх, тохиолдолыг хэлэлцэх, судалгааны арга аргачлалаас суралцах зэрэг шинжлэх ухаанч мэдлэг чадвараа дээшлүүлж, онол практикыг хослуулсан чадварлаг эмч, мэргэжилтнүүд, хамт олныг бүрдүүлэх үүднээс Эрдэм шинжилгээний журнал клубыг /цаашид “Журнал клуб” гэх/ Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн /цаашид “Төв” гэх/ хэмжээнд зохицуулахад энэхүү журмыг ашиглана.

4. **Хамрах хүрээ**

ЦССҮТ- ийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн болон бусад эрүүл мэндийн ажилтнуудад хамаарна.

5. **Үүрэг хариуцлага**

**5.1.** Төвийн дээд удирдлагын эрх, үүрэг

5.1.1. Төвийн Эрдэм шинжилгээний журнал клубын үйл ажиллагааг зохион байгуулахыг ЭШМТА-д үүрэг болгон, мэргэжил арга зүйгээр ханган хэрэгжилтэнд хяналт тавих

5.1.2. Журнал клубыг үйл ажиллагаа явуулах нөхцөл боломж, өрөө танхим, техник хэрэгсэлээр хангах

5.1.3. Журнал клубын хэлэлцэх сэдвийн чиглэл, хуваарийг баталгаажуулах

5.1.4. Журнал клубын үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх

### 5.2 ЭШМТА-сургалт төсөл хариуцсан ажилтны эрх, үүрэг

5.2.1 Журнал клубын ажиллах журмыг боловсруулж, төвийн захирлаар батлуулах, Цусны албаны эмч, мэргэжилтэнд танилцуулан сурталчлах

5.2.2 Журнал клубын хуваарийг алба, тасгуудтай зөвшилцөн боловсруулж, албаны даргаар хянуулж, батлагдсан хуваарийн дагуу тогтмол зохион байгуулж, баримтжуулах

5.2.3 Үйл ажиллагаатай холбоотой аливаа хүсэлтийг хүлээн авч, хэлэлцэн албан ёсоор хариу өгөх

5.2.4 Эмч, мэргэжилтнүүдийн оролцоог сайжруулах, идэвхжүүлэх, сонирхолтой хэлбэрээр зохион байгуулах, идэвхтэй сайн оролцсон эмч, мэргэжилтний ажил дүгнэх шалгуур үзүүлэлтэнд нэмэлт оноо болгон оруулах

5.2.5 Хуваарийн дагуу дараагийн илтгэгчдэд 7-10 хоногийн өмнө мэдэгдэх, мэдээлэх Эмч, мэргэжилтнүүдэд судалгааны сэдэв сонгох, илтгэл бэлтгэхэд нь арга зүйн дэмжлэг үзүүлэх

5.2.6 Анги танхим, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах

### 5.3 Төвийн эмч, мэргэжилтнүүдийн эрх, үүрэг

5.3.1 “Журнал клуб” – ын үйл ажиллагааны журмыг дагаж мөрдөх

5.3.2 Илтгэл тавих үед мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг туслалцаагаар хангагдах

5.3.3 Клубын үйл ажиллагааны чанартай холбоотой асуудлаар санал хүсэлтээ тавих, шаардлага тавих

5.3.4 Хүндэтгэх шалтгааны улмаас хуваарьт өдрөө илтгэл тавих боломжгүй тохиолдолд 7 хоногийн өмнө хариуцсан сургалтын мэргэжилтэнд даруй мэдэгдэж, дараагийн өдрийг товлох

5.3.5 Батлагдсан хуваарийн дагуу клубын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, цаг баримтлах, судлаачийн ёс зүйг дагаж, хүндэтгэлтэй хандах зарчимыг мөрдөнө.

5.3.6 Төлөвлөсөн хуваарийн дагуу эмч, мэргэжилтнүүд тухайн өдрөөс 10-14 хоногийн өмнө (Peer reviewed journal, Journal Impact Factor (JIF)) хамгийн сүүлийн үеийн шинжлэх ухааны судалгаа, нотолгоонд суурилсан өндөр үнэлгээ авсан тохиолдлууд, шинэлэг мэдээлэл, судалгааны ажлыг сонгон судласан байна.

## 6. Журмаар зохицуулах үйл ажиллагаа

### 6.1. Үйл ажиллагааны хэлбэр, материал арга зүй

6.1.1. Клубын үйл ажиллагаа нь зайн болон танхимаар сард 2 удаа зохион явагдана.

6.1.2. ЦССҮТ- ийн Google classroom –д журнал клубын материал, холбогдох мэдээлэлийг (PDF, Power point –PPT, JPG, Excel) байдлаар хуваарьт өдрөөс 7-10 хоногийн өмнө байршуулна.

6.1.3. Зарим оффисын программ (Google classroom, Google form, баримт бичиг хувиргах гэх мэт) дээр ажиллах заавърыг танилцуулах

6.1.4. Google calendar –т илтгэл тавих эмч, мэргэжилтнүүдийн батлагдсан хуваарийг оруулсан байна.

**6.2. Үйл ажиллагааны дэг**

6.2.1. **Илтгэгчийн үүрэг**

6.2.1.1. Хуваарийн дагуу дараагийн илтгэгч сонгосон судалгааны сэдвээ (PDF) Файлаар 10-14 хоногийн өмнө сургалт төслийн ажилтанд өгсөн байна.

6.2.1.2. Хуваарьт өдрөөс 10-14 хоногийн өмнө ЦССҮТ –ийн Facebook дотоод хуудсанд илтгэлийн сэдэв, зарыг тавина.

6.2.1.3. Илтгэгч сонгосон судалгааны ажилд Critical Appraisal analyze буюу шүүмж үнэлгээ хийж, дүгнэлт гарган, хавсралтад заасан агуулгын дагуу илтгэлийг бэлтгэнэ. (Маягт-1 ийг харна уу)

6.2.1.4. Илтгэгч Power point дээр бэлтгэсэн илтгэлээ хуваарьт өдрөөс өмнөх өдөр нь ЭШМТ –ийн албаны сургалт төслийн ажилтаны nctm.training@gmail.com руу илгээнэ.

6.2.1.5. Илтгэгч судалгааны дүгнэлтээ 15-20 минут хугацаанд танилцуулах ба хэлэлцүүлэгийн асуулт хариулт 10-15 минут үргэлжилнэ.

6.2.1.6. Илтгэгч үйл ажиллгаа эхлэхээс 10 минутын өмнө ирж бэлтгэлээ хангах

6.2.2. **Оролцогчдын үүрэг хариуцлага**

6.2.2.1. Эмч мэргэжилтэнүүд үйл ажиллагаанд оролцохдоо хуваарьт өдрөөс өмнө ЦССҮТ ийн Google classroom –д тавигдсан PDF судалгааны ажил буюу шаардлагатай материалыг урьдчилан уншиж танилцсан байна.

6.2.2.2. Оролцогч эмч, мэргэжилтнүүд илтгэл тависан судалгааны бүтээлд шүүмж дүгнэлт хийж, зөвлөмж, дүгнэлтээ цахимаар google form дээрх асуумжын дагуу бөглөх буюу цаасаар өгсөн байна. (Маягт–2 Үнэлгээний хуудсыг харна уу)

6.2.2.3. Оролцогч эмч, мэргэжилтнүүд үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, цагийг баримтлан, судлаачийн ёс зүйг дагах, хүндэтгэлтэй хандах зарчимыг дагаж мөрдөнө.

**6.3. Удирдлага зохион байгуулалт, хяналт үнэлгээ**

6.3.1. Сургалт төслийн ажилтан асуумж судалгааг хагас жилд нэг удаа авч, түүнийг үндэслэн үнэлгээ, дүгнэлт хийж, үйл ажиллагааг хөгжүүлэх

6.3.2. Жилийн эцэст бүх алба, тасгын эмч, мэргэжилтэнүүдийг ирцийн бүртгэл болон оролцсон байдлын тайлан мэдээг тайлагнан танилцуулах

**6.4. Судалгааны чиглэл**

6.4.1. Эмнэлгийн удирдлага, зохион байгуулалт, нийгмийн эрүүл мэнд

6.4.2. Эмнэлзүйн цус сэлбэлт, цус, цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээ, эмчилгээний үр дүн

6.4.3. Цусны аюулгүй байдал (Hemovigilance)

6.4.4. Донор зохион байгуулалт, донорын сургалт, сурталчилгаа, маркетинг

6.4.5. Цус сэлбэлтээр дамжих халдвар

6.4.6. Иммуногематологи, иммнуногенетик

6.4.7. Биобэлдмэлийн үйлдвэрлэл, сийвэнгийн бэлдмэл бэлтгэх технологи

6.4.8. Олон улсад хэрэгжүүлж буй сувилахуйн тусламж үйлчилгээний чиг хандлага
6.4.9. Олон улсын цусны төвүүдэд ашиглаж буй орчин үеийн шинэ техник, технологийн хэрэглээг
6.4.10. Олон улсын Эмнэлгийн санхүү, эдийн засгийн чиг хандлага
6.4.11. Бусад шинэлэг мэдээ, мэдээлэл

## 7. Лавлах, эш татсан материал

7.1.1. Монгол улсын Эрүүл мэндийн тухай хууль
7.1.2. Боловсролын тухай хууль
7.1.3. Дээд боловсролын тухай хууль

## 8. Хавсралт

**8.1. Маягт - 1: Илтгэл тавих агуулга** **М-ЭШ-4-01**

**1. Илтгэл монгол хэл дээр**

- **Судалгааны товч танилцуулга:** Судалгааны ажлын үндэслэл, зорилго, зорилт, шинэлэг талыг тусгах
- **Судалгааны материал, арга зүй:** Судалгааны загвар, хэрэглэгдэхүүн, хамрах хүрээ, судалгааны арга, мэдээ материал цуглуулсан арга, статистик боловсруулалтыш дурьдах
- **Үр дүн:** Судалгааны үр дүнг тодорхой бичих, үр дүнгийн тайлбарыг хүснэгт болон зургаар (график болон фото зургаар) илэрхийлэх
- **Хэлцэмж:** Судалгааны ажлын давуу ба сул талыг тусгах, онол болон практик ач холбогдолыг тодорхойлох, өөрийн мэргэжлийн салбарын үйл ажиллагаатай харьцуулсан дүгнэлт хийх
- **Дүгнэлт:** Үр дүнд тулгуурласан дүгнэлтийг товч тодорхой танилцуулах
- **Ном зүй:** Ашигласан хэвлэлийн жагсаалт Vancouver буюу APA Citation Style баримтлан бичнэ.

**2. Presentation in English**

- Introduction:
  - Background- Thesis statement
- Methodology:
  - Study design, type, population,
  - Randomization (Inclusion and exclusion criteria)
- Results:
- Discussion
- Conclusion:
- References:

**8.2. Маягт- 2 Журнал клубын оролцогчдын ирцийн бүртгэл** **М-ЭШ-4-02**

| № | Овог нэр | Алба тасаг | Тушаал | Гарын үсэг |
|---|---|---|---|---|
| 1 | | | | |
| 2 | | | | |
| 3 | | | | |
| 4 | | | | |
| 5 | | | | |
| 6 | | | | |
| 7 | | | | |
| 8 | | | | |
| 9 | | | | |
| 10 | | | | |
| 11 | | | | |
| 12 | | | | |
| 13 | | | | |
| 14 | | | | |
| 15 | | | | |
| 16 | | | | |
| 17 | | | | |
| 18 | | | | |
| 19 | | | | |
| 20 | | | | |

**8.3. Маягт- 3: Журнал клубын үнэлгээний хуудас** (Feedback form) **М-ЭШ-4-03**

# Journal Club – Үнэлгээ, зөвлөмжийн хуудас

Илтгэгчийн нэр: ........................................................ Огноо: . . . .

Сонгосон судалгааны сэдэв:

.......................................................................................................................................

Үнэлгээний асуумж:

1. Илтгэлд доорх агуулгыг багтаасан эсэх?
   Илтгэлийг товч ойлгомжтой бэлтгэсэн байдал
   . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .
   . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .
   Тохиолдол/судалгааны ажлыг оновчтой тайлбарласан байдал
   . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .
   Практик ач холбогдолыг тодорхойлсон
   байдал:
   . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .
2. Сонгосон судалгааны ажлыг ойлгомжтой илтгэснийг 1-5 хүртэл оноогоор үнэлнэ үү.
   (1 = Маш хангалтгүй, 2 =Хангалтгүй, 3 = Энгийн, 4 = Хангалттай, 5 = Маш хангалттай)

   1 2 3 4 5

   Танд санал, зөвлөмж байна уу.
   ..........................................................................................................................................
   .....................
   ..........................................................................................................................................
   .....................

## 9. Холбогдох баримт бичиг

**9.1.** Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн албаны үйл явцын тодорхойлолт ҮЯТ –ЭШ-2-01-02